



НАЛАЙХ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2016 оны 01 сарын 27 өдөр

Дугаар 8/11

Улаанбаатар хот

Г Авлигын эсрэг, авлигаас урьдчилан
сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөө
батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай (шинэчилсэн найруулга) хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт заасныг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дүүргийн Засаг даргын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 2016 оны эдийн засаг, нийгмийн зорилтод тулгуурлан авлигын эсрэг, авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хавсралт ёсоор баталсугай.
2. Авлигын эсрэг, авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газар (О.Манаарбек)-т даалгасугай.


ЗАСАГ ДАРГА

Х.БОЛДБААТАР



1126200042

Дүүргийн Засаг даргын 2016 оны
01.. дугаар сарын 27-ны өдрийн
А/11 дугаар захирамжийн хавсралт



НИЙСЛЭЛИЙН НАЛАЙХ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ
(2016 он)

Д/д	Хийх ажлын агуулга	Гүйцэтгэлийн үзүүлэлт	Хариуцах нэгж	Гүйцэтгэх хугацаа
1.	<p>Авлигын эсрэг соён гэгээрүүлэх, авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлэх</p> <p>Эрх зүйн үндэслэл: Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.6.1, 7.6.2;</p>	1.1 Авлигын эсрэг, авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг оны эхнээс төлөвлөж шаардагдах зардлыг тооцсон байх	Хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтэн	1 дүгээр улиралд
		1.2 Авлигын эсрэг, авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны үр дүнг тооцож цахим хуудсанд мэдээлэл байршуулах	Хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтэн	Жилдээ
		1.3 Авлигын эсрэг хууль тогтоомжийн биелэлтийг нэгтгэн удирдлагад тайлagnaх	Хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтэн	Хагас, бүтэн жилээр
2.	<p>Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, энэ талаарх мэдээллийг иргэд, байгууллага чөлөөтэй авах нөхцөлийг хангах</p> <p>Эрх зүйн үндэслэл:</p> <ul style="list-style-type: none"> • Авлигын эсрэг хууль 5 дугаар зүйлийн 5.1.2; • Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5; • Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2. 	2.1 Хууль тогтоомжийг сурталчлах өдөрлөг зохион байгуулах	Эрх зүйн мэргэжилтэн	8 дугаар сард
		2.2 Авлигын эсрэг хууль, түүнтэй холбоотой журмуудаар гарын авлага боловсруулж тараах	Захиргаа, хуулийн хэлтэс	Жилдээ
		2.3 Авлигаас урьдчилан сэргийлэх, хувийн ашиг сонирхол болон хөрөнгө орлогын мэдүүлгийн ач холбогдлын талаар таниулах, хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг, мэдэгдэл, хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд гаргах талаар сургалт зохион байгуулах	Захиргаа, хуулийн хэлтэс	1 дүгээр улиралд
		2.4 Удирдах албан тушаалтан, төрийн захиргааны албан хаагчдын дунд мэдлэг	Захиргаа, хуулийн хэлтэс	10 дугаар сард

		корих тэмцээн зохион байгуулах		
3.	<p>Төрийн хяналтын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах</p> <p>Эрх зүйн үндэслэл:</p> <ul style="list-style-type: none"> • Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3 	3.1 2016 онд явуулах хяналт, шалгалтын төлөвлөгөө, дүн, зөвлөмжийг цахим хуудсанд байршуулах	Хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн	Жилдээ
		3.2 Байгууллагын үйл ажиллагааг иргэд, үйлчлүүлэгчдээр үнэлүүлэх	Захиргаа, хуулийн хэлтэс	Жилдээ
4.	<p>Байгууллагын удирдлагаас гаргаж буй шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангах</p> <p>Эрх зүйн үндэслэл:</p> <ul style="list-style-type: none"> • Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.10; • Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4 	4.1 Байгууллагын удирдлагаас гаргаж буй шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангаж цахим хуудас, мэдээллийн самбар, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр мэдээллэх	Эрх зүйн мэргэжилтэн мэдээллийн технологи хариуцсан мэргэжилтэн	Тухай бүр
		5.1 Төрийн албан хаагчдын ажил үүргийн хуваарь, ажлын байрны тодорхойолт, хариуцсан ажил үүргийн талаарх мэдээллийг иргэд олон нийтэд нээлттэй байлгаж мэдээлэл авах боломжийг хангах	Хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтэн	
5.	<p>Хүний нөөцийн ил тод байдлын хангах, олон нийтийг түүнтэй танилцах боломжоор хангах</p> <p>Эрх зүйн үндэслэл:</p> <ul style="list-style-type: none"> • Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.5; • Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 8 дугаар зүйл 	5.2 Сул орон тоог нөхөх, сонгон шалгаруулах үйл ажиллагаа болон албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааны талаарх мэдээллийг байгууллагын цахим хуудсанд байршуулах	Хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтэн	Тухай бүр
		6.1 Төсвийн орлого, түүний зарцуулалт, гадаадын зээл, тусlamж, түүний хуваарилалтыг олон нийтэд тухай бүр мэдээлэх /цахим хуудсаараа/	Санхүү, төрийн сангийн хэлтэс	
6.	<p>Эрх зүйн үндэслэл:</p> <ul style="list-style-type: none"> • Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4; • Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 • Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.9 	6.2 Төсвийн орлого, түүний зарцуулалт, гадаадын зээл тусlamж, түүний хувиарлалтыг олон нийтэд мэдээллэх		Жилдээ

	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах, түүнтэй танилцах боломжоор хангах Эрх зүйн үндэслэл: <ul style="list-style-type: none">• Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4;• Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.3, 6.4.4• Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 21 дүгээр зүйл	7.1 Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа үйлчилгээ худалдан авах ажиллагааны нээлттэй ил тод байдлыг хангах, цахим тендерийг хэрэгжүүлэх	Санхүү, төрийн сангийн хэлтэс, Дүүргийн Худалдан авах ажиллагааны алба	Тухай бүр
7.	Aшиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ёс зүйн дүрмийг тогтоон мөрдүүлэх Эрх зүйн үндэслэл: <ul style="list-style-type: none">• Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.1, 7.2.2, 7.2.4,• Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.9, 6.1.6	8.1 Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын дарга нарын шийдвэр гаргах явцад нийтийн албан тушаалтан ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг гаргуулж хэвших	Хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтэн	Тухай бүр
8.	8.2 Ёс зүйн дүрэм, ёс зүйн хорооны үйл ажиллагаа, ёс зүйн зөрчлийн мэдээ тайланг цахим хуудсаар мэдээллэх	Хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтэн	Жилдээ	
9.	Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах Эрх зүйн үндэслэл: <ul style="list-style-type: none">• Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.12;• Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2	9.1 Авлигад өртөх эрсдэлтэй ажил, албан тушаалтны судалгааг гарган холбогдох байгууллага, нэгжид мэдээллэх	Хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтэн	2 дугаар улиралд
	9.2 Хууль болон Засгийн газраас зөвшөөрөгдсөн давхар ажил эрхэлж болох ажлын жагсаалтыг албан хаагчдад танилцуулах, давхар ажил эрхлэлтийн судалгаа гаргах	Хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтэн	2 дугаар улиралд	
10.	9.3 Авлигын эсрэг төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагаас гаргасан санал санаачилгад нэгдэх, дэмжиж ажиллах, сурталчлах	Захиргаа, хуулийн хэлтэс	Жилдээ	
	10.1 Мэдээллийн самбарын ажиллагааг	Захиргаа, хуулийн	Жилдээ	

	<p>хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх шат дамжлагыг цөөрүүлэх, зөрчлийн талаарх мэдээллийг хүлээн авч шалгах</p> <p>Эрх зүйн үндэслэл:</p> <ul style="list-style-type: none"> • Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.11; • Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2; • Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.3; 	<p>тогтмолжуулж, санал хүсэлтийн хайрцгаар ирүүлсэн санал хүсэлтийг удирдлагад танилцуулан удирдлагын шийдвэрт тусгуулах</p> <p>10.2 Иргэдийн санал хүсэлт, ажилтан албан хаагчидтай холбоотой ёс зүйн зөрчлийн талаарх мэдээлэл хүлээн авах нөхцлийг бүрдүүлж тогтмол утас ажиллуулах</p>	хэлтэс	
11.	<p>Авлигатай тэмцэх газраас бүрэн эрхийнхээ дагуу гаргасан шийдвэрийг биелүүлэх</p> <p>Эрх зүйн үндэслэл:</p> <ul style="list-style-type: none"> • Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.6, • Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 	<p>11.1 Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн зөвлөмжийн дагуу тодорхой ажил зохион байгуулах, үр дүнг тооцох</p> <p>11.2 Авлигатай тэмцэх газраас зөрчил арилгуулахаар хүргүүлсэн албан бичгийн биелэлтийг тооцох, хариуг тогтоосон хугацаанд хүргүүлэх</p>	<p>Хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтэн</p>	Жилдээ
12.	<p>Чиг үүргийн дагуу олгож буй зөвшөөрөл, бүртгэлийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, олон нийтэд танилцах боломжоор хангах</p> <p>Эрх зүйн үндэслэл:</p> <ul style="list-style-type: none"> • Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.5; • Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.8 	<p>12.1 Засаг даргын чиг үүргийн дагуу олгож буй зөвшөөрөл тусгай зөвшөөрөл, бусад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл гэх мэт/-ийн жагсаалт, олгоход шаардлагатай баримт бичгийн жагсаалт, шийдвэрлэх журмыг цахим хуудсандaa байршуулж иргэд, олон нийт нээлттэй танилцах боломжийг бүрдүүлэх</p>	<p>Захиргаа, хуулийн хэлтэс</p>	Жилдээ